



I-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 14



Бүх төрлийн тээврийн орлого 2021 оны 3 дугаар улиралд 351.4 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 27.4 (8.4%) тэрбум төгрөгөөр өслөө

Бүх төрлийн тээвэр

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2021 оны эхний 9 сард 35.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 (10.3%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.8 (32.6%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2021 оны эхний 9 сард 57.7 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 42.3 (42.3%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 40.4 (41.3%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2019 I-IX	2020 I-IX	2021* I-IX
Тээсэн ачаа, сая тонн	50.8	39.9	35.8
Зорчигчид, сая хүн	131.3	100.0	57.7
Тээврийн орлого, тэрбум төгрөг	1 506.3	1 047.7	1 018.4

Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2021 оны 3 дугаар улиралд, өмнөх улирлаас 42.2 (0.4%) мянган тонн, зорчигчид 23.5 (4.3 дахин) сая хүнээр тус тус өссөн байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2021 оны эхний 9 сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.3 (2.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Авто тээврийн орлого 54.7 (15.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Харин бүх төрлийн тээврийн орлого 2021 оны 3 дугаар улиралд 351.4 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 27.4 (8.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Авто замын тээвэр

Авто тээврээр 2021 оны эхний 9 сард 12.0 сая тонн ачаа, давхардсан тоогоор 57.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.8 (32.6%) сая тонн, зорчигчид 40.4 (41.3%) сая хүнээр буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 5.7 сая тонн буюу 37.4 хувь, зорчигч тээврийн бууралтад нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 38.0 (43.1%) сая хүнээр буурсан нь тус тус нөлөөлсөн байна.

Харин авто замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 10.7 (0.4%) мянган тонноор буурсан бол зорчигчид 23.4 (4.3 дахин) сая хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 2. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2019 I-IX	2020 I-IX	2021* I-IX
Тээсэн ачаа, сая тонн	30.4	17.8	12.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	25.5	15.2	9.5
Зорчигчид, сая хүн	127.9	98.0	57.5
Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчид	116.2	88.2	50.2
Тээврийн орлого, тэрбум төгрөг	571.8	350.5	295.7


Авто тээврийн салбарын орлого 2021 оны эхний 9 сард 295.7 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 54.7 (15.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин авто тээврийн орлого 2021 оны 3 дугаар улиралд 94.0 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 13.7 (17.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2021 оны эхний 9 сард 23.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.7 (7.5%) сая тонноор өсжээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА,
мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд дотоодод тээсэн ачаа 1.2 (15.3%) сая тонн, импортын ачаа 274.2 (12.5%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 9 дүгээр сард 2.7 сая тонн болж, өмнөх сараас 23.3 (0.9%) мянган тонноор өсжээ.

ХҮСНЭГТ 3. ТӨМӨР ЗАМААР ДОТООД, ГАДААДАД ТЭЭСЭН АЧАА,
бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний 9 сараар


Үзүүлэлт	2019 I-IX	2020 I-IX	2021* I-IX	Төмөр замын тээврээр 2021 оны эхний 9 сард уул уурхайн бүтээгдэхүүн 724.1 (5.2%) мянган тонн, барилгын материал 663.8 (37.5%) мянган тонн, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 30.9 (21.4%) мянган тонноор өмнөх оны мөн үеэс өсөж, харин хар төмөр 66.1 (22.9%) мянган
Бүгд	100.0	100.0	100.0	
Уул уурхайн бүтээгдэхүүн	83.1	82.5	80.5	
Барилгын материал	9.9	10.6	13.5	
Мод, модон материал	0.6	0.6	0.4	
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.9	1.0	
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.3	0.9	0.7	
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.4	1.7	1.2	
Бусад	2.7	3.0	2.7	

тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 15.5 (10.9%) мянган тонноор тус тус буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2021 оны эхний 9 сард 68.0 (давхардсан тоо) мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (95.9%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад ковид-19 өвчнөөс үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээврийг хязгаарласан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2021 оны эхний 9 сард 594.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.3 (3.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн тухайлбал, нүүрс, жонш, жоншны баяжмал болон барилгын материал, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД,
мянган хүн, сараар




Төмөр замын тээврийн орлого 2021 оны 9 дүгээр сард 67.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 86.8 (0.1%) сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд мод, модон материал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, нүүрс, зэс болон молибдений баяжмалын тээвэрлэлт өссөн нь нөлөөлсөн байна.

Агаарын тээвэр

Агаарын тээврээр 2021 оны эхний 9 сард 3.3 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 (69.8%) мянган тонноор өссөн байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, тонн, сараар




Агаарын тээврээр 2021 оны эхний 9 сард дотоодод 35.5 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 27.5 (43.7%) тонноор буурсан байна.

Харин олон улсад тээсэн ачаа 3.3 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (73.5%) мянган тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2021 оны 9 дүгээр сард 449.7 тонн болж, өмнөх сараас 9.5 (2.2%) тонноор өссөн байна.

ЗУРАГ 4. АГААРЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, мянган хүн, сараар



Агаарын тээврээр зорчигчид 2021 оны эхний 9 сард 114.5 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 279.2 (70.9%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр зорчигчид 2021 оны 9 дүгээр сард 20.9 мянга болж, өмнөх сараас 1.9 (9.8%) мянган хүнээр өссөн байна.

Энэхүү өсөлтөд Улаанбаатар-Истанбул-Улаанбаатар чиглэлийн зорчигчид 12.0 хувь, Улаанбаатар-Оюутолгой чиглэлийн зорчигчид 27.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2021 оны эхний 9 сард 61.9 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 179.9 (74.4%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Оюутолгой-Даланзадгад чиглэлийн зорчигчид 88.0 хувь, Улиастай чиглэлийн зорчигчид 87.0 хувь, Мөрөн чиглэлийн зорчигчид 84.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2021 оны эхний 9 сард 52.6 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 99.7 (65.5%) мянган хүнээр буурсан байна. Харин 2021 оны 9 дүгээр сард 11.7 мянган хүн болж, өмнөх сараас 1.1 (10.3%) мянган хүнээр өссөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны эхний 9 сард 128.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.2 (5.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны 9 дүгээр сард өмнөх сараас 483.0 (2.5%) сая төгрөгөөр өсөж, 19.5 тэрбум төгрөг болсон байна. Энэхүү өсөлтөд дотоодын нислэгийн зорчигчид 9.3 хувь, олон улсын нислэгийн зорчигчид 10.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Тооцох аргачлал

Ачаа эргэлт

Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт

Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр

Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого

Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



Эх үүсвэр

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын
ахлах статистикч О.Мандахзориг
Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212